



“ХАН-УУЛ ЗАМ ЗАСВАР АРЧЛАЛТ”  
ОНӨААТҮГ-Т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024 - 08 - 19 № 01/1445

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай газраас зарласан “Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрган хольц тээвэрлэх ажил” ХУЗЗАОНӨААТҮГ/20240101021 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Эх далайн очир” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

1.Тендерийн баримт бичгийн ТШЗ 16.1.2.2-д “Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй хүчин төгөлдөр лавлагааг авч материалд хавсаргаж ирүүлнэ” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-д “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй” гэж, 11 дугаар зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж заасан байна. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан ТШЗ 16.1.2-д “Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэж бичих. “Хэрэв шаардах бол хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу сонгож бичнэ” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 16.1.2.-д заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан байна.


2. Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод Зөвшөөрөл: Төв замын зөвшөөрөлтэй, хучлагатай байх, Ажил гүйцэтгэх аж ахуй нэгж өөрийн нэр дээр 12 ба түүнээс дээш өөрөө буулгагчтай байх” гэж тус тус шаардсан байна.

0003224

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно” гэж 12.7-д “Барааг үйлдвэрлэх, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх явцад баримтлах тусгайлсан шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаж болно” гэж тус тус заасны дагуу боловсруулсан байна.

Иймд “Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрган хольц тээвэрлэх ажил” ХУЗЗАОНӨААТҮГ/20240101021 дугаартай тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН